



## Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаардаг байгууллагуудын 2022 оны 2 дугаар улирлын шилэн дансны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн товч танилцуулга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаардаг 202 байгууллага нь 2022 оны 2 дугаар улирлын байдлаар шилэн дансны цахим системд нийт 15081 мэдээлэл байршуулах ёстойгоос 92,7% буюу 13979 мэдээллийг хуулийн хугацаанд, 5,9% буюу 899 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан бол, 1,3% буюу 203 мэдээлэл огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 92.7 хувьтай гарлаа.



Мэдээлэл байршуулалтыг өмнөх онуудын мөн үеийнхтэй харьцуулбал:



Засаг даргын харьяаны 202 байгууллагаас төрийн сангийн 20 байгууллагын улирлын мэдээ илгээлтийг хянах боломжгүй байдаг тул 182 байгууллагын мэдээ илгээлт хянагддаг. Гэвч энэ улиралд шилэн дансны үйл ажиллагаа шинэ системд шилжихдээ төсвийн ерөнхийлөн захирагч болох Боловсролын ерөнхий газарт тухайн салбарын байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаа хянагдах болсонтой холбоотойгоор боловсролын байгууллагуудын улирлын мэдээ илгээлт хянагдахгүй байна.

Хянагдаж байгаа 109 байгууллагаас 2-р улирлын мэдээг 74 байгууллага хуулийн хугацаандаа, 12 байгууллага хугацаа хоцорч илгээсэн ба 23 байгууллага огт илгээгээгүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээ илгээлт 67,9 хувьтай гарлаа.

Байгууллагуудын улирлын мэдээ илгээлтийг диаграммаар харуулав.



### **Дүгнэлт, санал**

Энэ удаагийн шалгалтаар шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулалт 92,7%, хуулийн хугацаанд мэдээ илгээлт 67,9%- тай, шилэн дансны шинэ цахим системд бүртгүүлэлт хангалтгүй байгаа зэрэг зөрчлүүд илэрлээ.

Шилэн данс хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээлэл байршуулах үйл ажиллагаанд гарч байгаа зөрчлүүд нь мэдээлэл байршуулах үүрэг бүхий албан хаагчийн хариуцлагагүй байдал, мөн мэдээлэл байршуулалтад тавих удирдлагын болон дотоод хяналт байхгүй зэргээс шалтгаалж байгаа тул цаашид төсвийн шууд захирагч нар шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, үүнд дотоод хяналтын нэгжийг татан оролцуулах мэдээлэл байршуулах үүрэг бүхий албан хаагчийн

ажлын хариуцлагыг сайжруулах, ажил дүгнэх үзүүлэлтэд харгалздаг болох, мэдээлэл байршуулж байгаа албан хаагчид шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулахдаа мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн гүйцэд, үнэн зөв байршуулах, мэдээлэл хоорондын уялдааг хангаж ажиллах шаардлагатай байна.

Цаашид анхаарч ажиллах 3 заалт зөвлөмж, 4-н заалт бүхий албан шаардлагыг Санхүү төрийн сангийн хэлтэст болон сумдын санхүү албанд хүргүүлээ.